



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/266

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4./в/, 29.2 дахь заалт, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн орон сууцны барилгын дээврээс ус их хэмжээгээр орж иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл алдагдаж байгаа тул засварын ажилд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.


2.Дээрх ажилд шаардагдах 194794321 /Нэг зуун ерэн дөрвөн сая долоон зуун ерэн дөрвөн мянга гурван зуун хорин нэгэн/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 11-ны өдрийн
А/266 дугаар захирамжийн хавсралт

**ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН БАЙРУУДЫН
ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

№	Зардлын нэр	Зардал /төгрөг/
1	Орон сууцны 4 дүгээр хорооллын 16 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	31066096
2	Орон сууцны 3 дугаар хорооллын 12 дугаар байрны 3 дугаар блокын дээвэр засварын ажил	17343537
3	Орон сууцны 5 дугаар хорооллын 4 дүгээр байрны 2 дугаар блокын дээвэр засварын ажил	17343537
4	Орон сууцны 5 дугаар хорооллын 1 дүгээр байрны 2 дугаар блокын дээвэр засварын ажил	16919886
5	Орон сууцны 5 дугаар хорооллын 21 дүгээр байрны 3 дугаар блокын дээвэр засварын ажил	19898566
6	Орон сууцны 6 дугаар хорооллын 14 дүгээр байрны 4 дүгээр блокын дээвэр засварын ажил	11891162
7	Орон сууцны 6 дугаар хорооллын 15 дугаар байрны 3 дугаар блокын дээвэр засварын ажил	21165628
8	Орон сууцны 1 дүгээр хорооллын 16 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	21543900
9	Орон сууцны 2 дугаар хорооллын 25 дугаар байрны 2 дугаар блокын дээвэр засварын ажил	19790957
10	Орон сууцны 3 дугаар хорооллын 17 дугаар байрны 1 дүгээр блокын дээвэр засварын ажил	17831052
	Дүн	194794321